



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 4/77

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын ой, хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сайжруулах, хамгаалах, тэмцэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэх ажлын хэсгийн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар хурлын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн “Ди Өү Эй Эс” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах гэрээ байгуулж гүйцэтгүүлсүгэй.

2. “Ди Өү Эй Эс” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Бат-Өлзий сумын ой, хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сайжруулах, хамгаалах, тэмцэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэх ажилд шаардагдах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАН